

Заах болон Сурах Зарчмууд

ЕРӨНХИЙЛӨГЧ БОИД К.ПАКЕР

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч

АХЛАГЧ Л.ТОМ ПЕРРИ

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын



Заах болон Сурах нь

Ерөнхийлөгч Пакер: Бидний өнөөдрийн ярилцах сэдэв маань Есүс Христийн сайн мэдээг анги болон гэртээ заах мөн сурах талаар байх болно. Бид бүгдээрээ— удирдагч, багш, номлогч болон эцэг эхийн хувьд энэ амьдралынхаа туршид Их Эзэний бидэнд илчилсэн сайн мэдээний сургаалуудыг сурах мөн бусдад заах үүрэг хариуцлагатай байдаг.

Бид одоо сайн заахын гол зарчмуудын талаар Ахлагч Л.Том Перри

бид хоёрын хооронд өрнөсөн товчхон яриагаар эхлэе. Заах болон сурах үйл явцын талаар надад ихээхэн зүйлийг сургасан хувийн туршлагаасаа хуваалцах үүрэг надад ноогдсон билээ. Хэрэв та нар анхааралтай сонсож мөн үзэх юм бол, сайн багш байхын тулд та түүнчлэн анхааралтай сайн сонсдог байх ёстой гэдгийг ойлгох болно.

Бидний ярилцлагын дараа Ахлагч Жеффри Р.Холланд заахдаа хэрхэн бэлтгэх талаар зааварчилгаа өгөх болно. Тэгээд дараа нь

тэрээр оюутнууд байгаа ангид орж ангид хэрхэн заах жишээг үзүүлнэ.

Арванхоёрын хэн нь ч үүнчлэн үр дүнтэй жишээ үзүүлж чадна. Тэд бүгд бие биенээсээ ялгаатай аргуудыг хэрэглэх байх. Бүх багш нарт, бүх нөхцөл байдалд тохирсон нэг арга гэж байхгүй. Тодорхой нөхцөлд өөрсдийгөө бэлтгэх, дадлага туршлага, хувийн зан чанар, мэдлэг болон гэрчлэлээ тухайн хичээл дээр ашиглахад Ариун Сүнс биднийг чиглүүлдэг.

Удирдлагуудын үүрэг хариуцлага

Удирдлагууд нь зөвлөлийн хурал, ярилцлага, ариун ёслолын цуглаан хаана ч байсан заах үүрэг хариуцлагатай байдаг. Мөн тэд гишүүдийн амьдралд багшийг хөгжүүлэх хийгээд сайн мэдээнээс үр дүнтэй суралцах явц байнга явагдаж байгаад анхаарал хандуулах үүрэг хариуцлагатай.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Тэргүүн Зөвлөл 2006 оны арваннэгдүгээр сарын 17-нд хэсэг, гадасны багшийг хөгжүүлэх зохицуулагч хэмээх дуудлагат ажлыг зогсоосон захиаг илгээсэн юм. “Багшийг хөгжүүлэх үүрэг хариуцлага бүхий удирдлагууд” гэсэн жагсаалтыг захидлын хавсралт болгон явуулсан билээ. Энэхүү шууд нэвтрүүлгийн үед заагдах зарчмууд, захидалд дурдагдсан санал зөвлөмжүүд болон эх үүсвэрүүдийг ашиглаад санваартны болон хавсралт байгууллагуудын удирдлагууд маань сайн мэдээг заах болон сурах үйл явцыг сайжруулах талаар хэлэлцэнэ гэж бид найдаж байна. Мөн багшийг хөгжүүлэх талаар тусгай хурал цуглаан хийх шаардлагагүй бөгөөд зөвхөн зөвлөлийн хурал хийх үеэрээ болон шаардлага гарсан үед



Энэхүү Дэлхий дахины удирдагчдын сургалт дээр хэлэгдсэн үгс нь таныг багш, сурагчийн хувьд өсч хөгжихөд туслах болно. Яригдсан зүйлсийг сурч мөн хичээлдээ ашиглахын тулд хэлэгдсэн үг бүрийн эхэнд байгаа шар дөрвөлжин доторх мэдээллийг унш. Түүнчлэн та судруудыг болон уг танилцуулгын гол хэсгийг тэмдэглэж, төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэж болох юм.

Ерөнхийлөгч Пакерын хэлсэн үгийг унш. Таныг илүү сайн багш мөн сурагч болоход тань туслах санаануудыг олж тогтоо.

Дараах асуултуудыг тунгаан бодож, өөрт төрсөн сэтгэгдэл болон санаануудыг бичиж ав: Гэртээ болон сүмд заахдаа Ариун Сүнснийг өөртэйгөө хамт байлгахын тулд би юу хийх ёстой вэ?

Ерөнхийлөгч Пакерыг илүү сайн сурагч болоход нь юу тусалсан гэж бодож байна вэ?



ярилцлага хийх замаар үүнийг зохицуулж болно.

Энэхүү шууд нэвтрүүлж буй сургалт маань та бүхнийг Есүс Христийн сайн мэдээний сайн багш, сурагч болоход тань туслах болтугай хэмээн бид залбирч байна.

Сурах хүсэл сонирхолтой байх нь

Ахлагч Перри: Ерөнхийлөгч өө, та *Teach Ye Diligently* гэдэг ном бичсэн. Сүмийн бүх л хэсэгт үр дүнтэй багш шаардлагатай байдаг. Энэ бол бидний хамгийн чухал дуудлага. Сүмийн дуудлагуудын маань нэг хэсэг болох үр дүнтэй заах талаар таньтай хэдэн минут ярьж болох уу?

Ерөнхийлөгч Пакер: Би семинарын зохицуулагчаар томилогдсон бөгөөд надад үүний талаар ямар ч ойлголт байгаагүй юм. Гэхдээ би томилогдсон учраас Сүмд очин семинарын багш нарт хэрхэн заах болон тэд юуг буруу хийснийг хэлж зөвлөх ажилтай боллоо. Аль нэг ангид очин багш нарын хийж байгаа зүйлсийг засаж залруулахдаа, би ч бас ингэж алддаг шүү дээ гэж боддог учир үүнээсээ би их ичдэг байв. Гэвч би үүнээс маш олон зүйл сурсан юм.

Ахлагч Харолд Б.Лий, Ахлагч Марион Ж.Ромни хоёр надад үргэлж шинэ зүйлийг зааж өгдөг байсан. Магадгүй тэд намайг одоогийн энэ дуудлагат ажлыг хийнэ гэж төсөөлөөгүй байх л даа, гэхдээ би сурахыг чин сэтгэлээсээ хүсэж байсан учраас тэдэнд хэзээ ч дургүйцдэггүй байсан сайн талыг минь тэд анзаарсан болов уу гэж би боддог. Заримдаа чи мэдэх шаардлагагүй гэж бодож байсан тийм зүйлийг ч, хэрэв чи дургүйцэхгүй байж мөн суралцахыг хүсвэл Их Эзэн танд заасаар байх болно.

Энэ хоёр гайхамшигтай багш надад заадаг байсан. Би Ромни ахтай тааралдах үед заримдаа тэр “Хүү минь чамд хэлэх зүйл байна” гэдэгсэн. Тэгээд л би хийх ёсгүй зүйл хийснээ ухаардаг байлаа. Мэдэхгүй зүйлийг минь зааж өгсөнд би түүнд үргэлж талархдаг байсан.

Ахмад хүмүүсийн туршлагыг сонсож сурах нь их чухал гэдгийг би бүр залуу байхдаа сурсан юм. “Би гайхамшигтай хүмүүсийн дэргэд байхыг үргэлж хичээдэг” гэж манай гадасны нэг ерөнхийлөгч надад хэлж билээ. Тэр Айдохогийн нэгэн жижиг хотод амьдардаг байсан юм. “Ямар нэг зүйл сурч мэдэхийн тулд хэн нэгэн хүн

лекц уншихаар ирэх эсвэл ямар нэг онцгой зүйл болвол би үргэлж тэнд байхыг хичээдэг байсан” гэж тэрээр хэлсэн юм.

Ахмад хүмүүстэй хамт байх гэж би үргэлж хичээдэг байж билээ. Одоо ч би тэдний нэг болж дээ. Арванхоёрын Чуулгын Лий Гранд Ричардс бусад ах нарын адил хурдан алхаж чаддаггүй байсан бөгөөд би түүнийг үргэлж хүлээн хаалгыг нь онгойлгон өгч хамтдаа байр руугаа буцаж алхдаг байв. Нэг удаа Ах нарын нэг нь “Чи Ричардс ахад санаа тавьдаг сайхан сэтгэлтэй хүн юм” гэж хэлэхэд нь би дотроо, “Миний аминч шалтгааныг та мэдэхгүй шүү дээ” гэж бодов. Би түүнтэй хамт алхахдаа түүнийг зөвхөн сонсдог байсан юм. Тэр Вилфорд Вуудраффийг дурсан, түүний тухай ярьдаг байв. Ганцаарчлан заах нь маш хүчирхэг арга юм. Ерөнхийдөө та зөв гэж бодсон үедээ ганцаарчлан заах тохиолдол гардаг.

Сайн заахын өөр нэгэн зарчим нь өглөө эртлэн босох (С ба Г 88:124-г үз) — үүний нэг амархан эсвэл хэцүү тал нь гэвэл орой эрт орондоо орох явдал бөгөөд өглөө эрт оюун санаагаа сэргэг байгаа дээр тунгаан бодох нь юм. Тэр үед жинхэнэ заах санаа орж ирдэг юм.

Ямар нэгэн үүрэг даалгавар аваад юу ч хийхээ мэдэхгүй байх үе надад олон байсан. Өчигдөр би Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн хуралд сууж байлаа. Би түрүүлж ярина гэдгээ мэдэж байв. “Юу ярих билээ?” гэж бодож байсан боловч хэлэх зүйл маань орж ирнэ гэсэн итгэлтэй байсан бөгөөд үнэхээр ирсэн юм.

Судруудыг ашиглах нь

Ахлагч Перри: Багшлахдаа судруудыг ашиглахын чухал нь юу вэ?

Ерөнхийлөгч Пакер: Би судруудад үргэлж найддаг. Сайн мэдээг заах хамгийн шилдэг үлгэр жишээ, заах арга барилын хамгийн сайн үлгэр дуурайлал бол Их Эзэн болон түүний заах арга барил юм. Тийм ч учраас би гартаа сударгүйгээр ангийн өмнө эсвэл индэр дээр гарах дургүй байдаг. Өнөөдөр миний гарт судрууд минь байна.

Ахлагч Перри: Ерөнхийлөгч өө, Та тэдгээр судруудыг өөртөө байнга авч явдаг. Тантай хамт байх үе бүрт танд тэдгээр судрууд байж л байдаг. Та бидэнд судрууд чинь хэрхэн норсон мөн энэ нь ч сайн хэрэг болсон бөгөөд та хуудсуудыг нь хурдан эргүүлэх боломжтой болсон тухай дурсан ярьж байсан.

Ерөнхийлөгч Пакер: Би гадаа зүлгэн дээр судраасаа судалж байлаа, хэн нэгэн намайг дуудахад би номоо дэлгээстэй хэвээр нь жижигхэн ширээн дээрээ орхиод яг л хөгшин хүн шиг мартчихсан гэтэл зүлэг устгагч ажиллаж судрыг минь норгочихсон юм. Өглөө нь би гарч хараад “50 жилийн турш тэмдэглэж ирсэн судар маань өнгөрлөө” гэж бодов. Гэвч би тэдгээр судруудын хуудас нь л зөвхөн норсон болохыг мэдсэн юм. Хэрвээ би шинэ судартай болох юм бол тэднийг хэрэглэхээсээ

өмнө бороонд норгоно гэж бодож байгаа.

Ахлагч Перри: Хүмүүс бидэнтэй үргэлж судруудын талаар ярилцдаг ба зарим нь тэднийг уншиж дуусгах нь ямар хэцүү байдаг тухай хэлдэг. Өөрийнхөө зааж буй хичээлээ судартайгаа хэрхэн холбож хүмүүст хүргэх вэ?

Ерөнхийлөгч Пакер: Судраа заавал уншаарай. Мормоны Номыг уншихаар шийдсэн тэр үеэ би санаж байна. Тэгэхэд би залуу хөвгүүн байсан. Номоо дэлгээд, “Би Нифай, буянт сайн эцэг эхээс мэндэлсний учир” (1 Нифай 1:1) гэж эхлэн цааш нилээн хэдэн бүлгүүдийг уншиж олон зүйл сурсан юм. Энэ нь маш сонирхолтой байсан бөгөөд би Хуучин Гэрээний бошиглогчдын хэллэгтэй Исаиагийн бүлэг хүртэл уншаад зогссон. Тэгээд хэдэн сарын дараа би Мормоны Номыг дахин уншихаар шийдэж номоо дэлгээд — “Би Нифай, буянт сайн эцэг эхээс мэндэлсний учир” хэмээн уншдаг байлаа. Гэвч ингэх болгонд Исаиагийн эдгээр бүлгүүд надад саад болж, энэ хэсэг яагаад энд байдгийг гайхдаг байв. Эцэст нь би тэдгээр бүлгүүдийг ч уншихаар шийдэв. Гэхдээ би өсвөр насны хөвгүүн байхдаа зөвхөн үгүүдийг нь уншиж сайн ойлгодоггүй байсан ч

цааш уншсаар л байдаг байсан. Та Алма дээр нэг ирчихвэл цааш нь уншихад амархан байх болно.

Тийм учир та тэднийг уншиж дуусгах шийдвэр гаргах ёстой. Мөн та энд тэндээс түүж битгий уншаарай харин Мормоны Ном, Шинэ Гэрээ, Сургаал ба Гэрээ мөн Аугаа Их Үнэт Сувдыг эхнээс нь дуустал нь унш. Жил бүрийн зун судруудаа дахин унших дадлыг би олон жилийн турш мөрдсөөр байгаа бөгөөд ийнхүү мэдлэгээ сэргээдэг уламжлалтай болсон юм.

Заах бэлгийн төлөө залбир

Ахлагч Перри: Багш болохоор дуудагдаж байгаа шинэхэн хөрвөгчдөд анхны дуудлагатай нь холбоотой ямар зөвлөгөөг та өгөх вэ?

Ерөнхийлөгч Пакер: Би тэдэнд та нар үүнийг хийж чадна гэж хэлмээр байна. Хүн бүр зааж чадна. Би тэдэнд заах бэлгийн төлөө залбир гэж зөвлөмөөр байна. Мормоны Номонд бэлгүүдийн талаар өгүүлсэн байдаг. Тэдгээрийн дунд Ариун Сүнсээр сайн мэдээг заах бэлгийн тухай өгүүлдгийг та нар мэднэ (Моронай 10:8–10-ыг үз). Би үүнийг олон жилийн өмнө уншаад, “Ариун Сүнсээр зааж болох энэ л бэлгийг би хүсэж байна” гэж бодсон. Үүний тулд асуух ёстойг би судруудаас олж мэдсэн — асуу чамд өгөгдөх болно. Ийм учраас би тэдэнд үргэлж асууж мөн эрэлхийлж бай “чи олох болно” (Матай 7:7; 3 Нифай 27:29-г үз), энэ нь амархан ирэхгүй ч чи үүний төлөө шаргуу байх хэрэгтэй гэж хэлмээр байна.

Сүнсийг эрэлхийлэх нь

Ахлагч Перри: Ариун Сүнсээр заахын тулд багш нар юу хийх ёстой вэ?



Ерөнхийлөгч Пакер: Зөв зохистой амьдарч, тусламж хүсэх хэрэгтэй. Эцэг эх хоёр ч тусламж авч болно. Мөн зарлигуудыг дуулгавартай дага, хэзээ хийх, юу хийхээ мэдэж болохын тулд ур чадвар урам зоригын төлөө байнга зогсолтгүй залбирч бай. Их Эзэн чамд туслах болно. “Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар руу ирнэ” (Иохан 14:18) “Иймийн тул, Та Христийн нэрээр хүлээн авах болно хэмээн найдаж итгэлтэйгээр гуйсан юуг ч болов, та хүлээн авах болно” энэ нь танд өгөгдөх болно (Инос 1:15) гэсэн байдаг. Мөн нэг судар үүн дээр бага зэрэг нэмээд, хэрэв энэ нь танд хэрэгтэй бол гэсэн байдаг (Моронай 7:26-г үз). Сайн мэдээ бол маш энгийн юм.

Та магадгүй өөрийнх нь хийх зүйл дууссан хөгшин хүн гэж өөрийгөө боддог, магадгүй та бүх зүйлсээс эмээдэг залуу хүн байж болох юм, эсвэл та хүүхдүүдээ өсгөөд маш завгүй байдаг ээж, эсвэл маш их ажилтай эцэг хүн байж болох ч та зааж чадна, та залбирч чадна, мөн та хөтлөгдөж чадна. Таныг Их Эзэн адислах болно гэдгийг би амлаж байна.

Их Эзэн багшилж байхдаа үргэлж хүмүүсийн мэддэг зүйлсийг ашигладаг байсан. Жишээ нь “тэнгэрийн хаанчлал нь загасны том тортой адил” (Матай 13:47) — гэсэн нь загасны торны тухай бус харин тэнгэрийн хаант улсыг тортой зүйрлүүлэн хэлсэн хэрэг юм. Дараа нь Тэрээр яагаад гэдгийг нь тайлбарласан байдаг. Мөн “тэнгэрийн хаанчлал бол сайн сувд хайгч худалдаачинтай адил юм” (Матай 13:45). Тэр тариачны тухай сургаалт зүйрлэлийг хэлэхдээ (Матай 13:3-8-ыг үз) энэ нь тэдэнтэй

ямар нэг байдлаар холбогдон мөн боломжтой байгаад зогсохгүй тэрээр тариачны тухай сургаалт зүйрлэлд үр хэрхэн хатуу газар дээр, хөрслөг хөрсөнд суулгагдсан талаар ярьсныг сарын дараа уг сургаалт зүйрлэлийг сонссон нэгэн гартаа үр барин суулгах гэж байхдаа ухаарах болно.

Хэрвээ чи хичээлдээ сургаалт зүйрлэлүүд, түүхүүд мөн үзүүлэнгүүдийг хэрэглэх юм бол тэд хэзээ ч мартагдахгүй. Түүний арга барил нь гайхалтай энгийн байсан юм. Тэр зарим үед хатуу чанга байсан ч үргэлж хүмүүсийн түвшинд тааруулж заадаг байсан юм.

Багшилна гэдэг бол ариун нандин дуудлага. Багш нарт хандаж хэлэхэд та нар хэзээ ч ганцаараа заадаггүй шүү. Та нар ганцаараа байх шаардлагагүй. Их Эзэн судрууд дээр үүнийг амласан байдаг. “Хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ач ивээл та нартай байх болно” (С ба Г 88:78-ыг үз) хэмээн Их Эзэн бүх

үндэстэн, хэлтэн, багш нарт амласан болохыг Алма өгүүлсэн байдаг (Алма 29:8-ыг үз).

Байнгын залбиралгүйгээр хэрхэн сайн мэдээг заах билээ. Та нар залбирлыг амаараа хэлэхээс гадна оюун санаандаа залбирч чадна. Ангид болон хэсэг бүлэг хүмүүст зааж байхдаа би маш олон удаа дотроо “Би юу хийх ёстой вэ?” хэмээн залбирдаг. Мөн би энэ хүчгүй байсан бол юу хийхээ мэдэхгүй байсан.

Заах үүрэг хариуцлага

Ахлагч Перри: Сүмийн бүх үйл ажиллагаануудад хамгийн чухал нь заах үйл явц байдаг. Өөрсдийгөө заахад бэлтгэх үүрэг хариуцлага хэнийх вэ?

Ерөнхийлөгч Пакер: Хүн бүр багш— удирдагч, дагалдагч, зөвлөх, мөн эцэг эхчүүд бүгд багш. Тийм учраас бид заах зарчмуудаас суралцах үүрэг хариуцлагатай. Их Эзэн өөрийн Сүмийг байгуулсан. Бид бүх зүйлийг сүм дотор хийдэг. Сургаал ба Гэрээнд “хүн болгон Их Эзэн Бурханы, бүр дэлхийн Аврагчийн нэрээр ярьж болохын тулд буюу” (С ба Г 1:20-ыг үз) гэсэн мэдэгдэл байдаг. Бүх ах нар санваартан байх боломжтой. Мөн бүх эгч нар Сүмд дуудлагат ажилд дуудагдах эрхтэй. Мөн бид бүгдээрээ эцэг эх болох болно. Тийм учраас бидний хийж буй бүх зүйлийн үндэс нь заах юм.

Ахлагч Перри: Гэрт заах талаар та өмнө нь ярьж байсан. Гэрт заах Сүмд заах хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ? Үүнд ямар нэг онцын ялгаа байна уу?

Ерөнхийлөгч Пакер: Гэрт заах нь илүү ойр дотно, амархан, албан ёсны бус мөн эцэг эхчүүд үлгэр жишээгээрээ зааж болдог.





Та зөв зохистой амьдрах ёстой мөн та тусламж хүсэх ёстой. Хэрэв та эцэг эх бол тусламж хүсч болно. Мөн та зарлигуудыг дагаж, юу хийх хэзээ хийхээ мэдэж болохын тулд ур чадвар хийгээд урам зоригын төлөө байнга мөн зогсолтгүй залбир.

Хүүхдүүд “яагаад” гэсэн асуулт асуухад нь та “тийм л байх ёстой учраас” гэж хариулдаг. Яагаад гэдгийг нь мэдэхгүй ч гэсэн та энэ бол хийх ёстой зүйл биш гэдгийг мэднэ. Тийм учраас тэдэнд дуулгавартай байдлын талаар зааснаар тэд мэдэж бас ойлгох болно. Гэр бүлд хүчирхэг хайраар эцэг эх хүүхдүүд холбогдсон байдаг ба та тэдэнд тэднийг ухаартал нь үргэлж зааж хэлж байх ёстой.

Сүнсээр заах нь

Ахлагч Перри: Ерөнхийлөгч өө, анги дахь Ариун Сүнсний нөлөөг хүүхдүүдийн хувьд үнэтэй туршлага болгохын тулд багшаас сурагчдад хэрхэн мэдрүүлэх вэ?

Ерөнхийлөгч Пакер: Нэгдүгээрт, тэдэнд заахыг хүсэж байгаа таны хайрыг тэд мэдрэх ёстой. Тэгснээр, та тэдний түвшинд заах болно. Бид ялангуяа сайн мэдээг заахдаа тэдний түвшнээс дээгүүр буюу тэдний ойлгохгүй байгаа зүйлийг ярьдаг. Их Эзэн ингэж заагаагүй. Их Эзэн өдөр бүр тэдэнтэй хамт байж, тэдэнтэй ярилцаж, үргэлж тэдний түвшинд тааруулж заадаг байсан.

Хэрэв та тэдэнд заах юм бол тэд

үнэхээр сурах хүсэлтэй байдаг. Тэр тусмаа өсвөр насныхан сурах хүсэлтэй байдаг юм. Тэд үүгээр цангаж байдаг.

Ихэнх багш нар өгүүлбэр бүрээр нь бэлтгэх ёстой гэж боддог. Тийм ч байж болно, үгүй ч байж болно. Тэрхүү бэлтгэл нь оюутнуудыг оролцуулж, тэдэнд асуулт асуух боломжийг олгож, хичээлд оролцуулах хангалттай цагийг багтаасан танилцуулгыг бэлтгэхийг шаарддаг. Мөн та илчлэлтэд зориулж тусгай зай гаргах хэрэгтэй.

Бидний санах ой Ариун Сүнсээр өдөөгдөж байдаг тул хэрвээ бид ямар нэг зүйлийг заахад бэрхшээлтэй байвал, мөн бид өөрсдийгөө хэн болох юу хийдэг талаар бодох болон явж үзсэн газар, харсан зүйлс гэх мэт өөрт байгаа туршлагаа хичээлдээ ашиглаж болно. Судрууд нь эдгээрийн нэг хэсэг юм. Тэдгээр нь зөвхөн уншихад зориулагдсан эсвэл Сүмийн дүрэм журмыг ойлгоход зориулагдсан ном биш юм.

Сүмд заагдаж буй зарим зүйлс нь хэтэрхий лекц маягаар явагддаг. Ангиудад лекц уншиж байгаа багш нарт бид анхаарлаа тийм ч сайн хандуулж чаддаггүй. Бид Ариун

ёстолын цуглаан болон чуулганд л үүнийг хийдэг. Гэхдээ заах нь хоёр арга замаар явагддаг. Та асуулт асууж болно. Та асуултандаа маш амархан хариулт авах болно.

Та Иосеф Смитийн үхлийн талаар зааж байна гэж бодъё. Сүмийн түүхийн багш та бүгдийг нь судалсан, Бошиглогч 1844 оны зургадугаар сарын 27-ны орой 5 цагт Картхейжийн Шоронд буудуулж нас барсан гэдгийг бүгдийг нь судалж суралцсан. Хэрэв та сурагчдаасаа Бошиглогч хэдэн цагт хаана буудуулсныг асуух юм бол тэдний хэн нь ч хариулахгүй байх болно. Та ч гэсэн гарын авлагыг уншихаасаа өмнө мэддэггүй байсан. Харин та “Юу түүнийг ийм байдалд хүргэв? Энэ талаар та нар юу гэж бодож байна? гэж асуу. Та нар юу гэж бодож байна гэж асуух тэр агшинд тэдэнд хэлэх зүйлс гарч ирэх болно. Тиймээс асуулт асууж, ангийг хичээлд ороцуулах арга байдаг. Асуусан асуултанд нь хариул. Ангиас чөлөөтэйгөөр асуулт асууж болно.

Хаанаас олохоо мэдэхгүй бол ямар нэг зүйлийг өгч чадахгүйн адилаар мэддэгээсээ илүүг ч зааж чадахгүй учраас Ариун Сүнсийг өөртэйгөө хамт байлга. ■